

**БАТЛАВ.**

**БОАЖЯ-НЫ ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН**

**БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА**

.....Ц.УРАНЧИМЭГ



**ЗӨВШӨӨРЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:**

**“ЭНХТУНХ ОРЧЛОН” ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ**

..... МАТТЮ КРАУФОРД

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН НОЁН СУМ  
ХАР СЭРВЭГЭН НҮҮРСНИЙ УУРХАЙН ТӨСЛИЙН  
2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ  
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН НЭР, ДУГААР: ХАР СЭРВЭГЭН, MV-019149  
АЖ АХУЙН НЭГЖИЙН НЭР, РЕГИСТРИЙН ДУГААР: “ЭНХТУНХ ОРЧЛОН” ХХК, 5618339

**Хянасан:**

Хүрээлэн Буй Орчин Байгалийн Нөөцийн Удирдлагын Газрын ахлах шинжээч:

.....Ц.ЖАРГАЛНЭМЭХ

**Боловсруулсан:**

“Энхтунх Орчлон” ХХК-ийн Байгаль орчны мэргэжилтэн:

.....Ж.БАНЗРАГЧ

**Улаанбаатар хот 2023 он**

**ГАРЧИГ**

<b>1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА.....</b>	<b>5</b>
1.1. Оршил.....	5
1.2. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж байгууллагын мэдээлэл.....	6
1.3. Төслийн байршил.....	6
1.4. Ордын судалгааны түүх.....	7
1.5. Уурхайн барилга байгууламж.....	7
1.6. Уурхайн дэд бүтэц.....	9
<b>5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ .....</b>	<b>19</b>
<b>6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ .....</b>	<b>22</b>
<b>7. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА .....</b>	<b>23</b>
<b>8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ .....</b>	<b>25</b>
8.1. Болзошгүй нөлөөллийн товч тодорхойлолт.....	25
<b>9. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....</b>	<b>26</b>
<b>10. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....</b>	<b>27</b>
<b>11. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....</b>	<b>29</b>
<b>12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ.....</b>	<b>32</b>
12.1. Орчны хяналт шинжилгээний ажлын төлөвлөгөө.....	32
12.2. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	35
<b>13. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ.....</b>	<b>39</b>
<b>14. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ .....</b>	<b>41</b>
<b>15. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗАРДАЛ.....</b>	<b>42</b>

**ЗУРАГ**

Зураг 1. Ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайн байршил .....	7
Зураг 2. Хамрах хүрээ .....	18
Зураг 3. Уурхай орчмын хяналт шинжилгээний хэмжилтийн цэгүүдийн байршил.....	33
Зураг 4. Уурхай орчмын хяналт шинжилгээний хэмжилтийн цэгүүдийн байршил.....	33

**ХҮСНЭГТ**

Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжийн тухай мэдээлэл.....	6
Хүснэгт 2. Тусгай зөвшөөрөлтэй талбайн өнцгийн солбицолууд - Хар Сэрвэгэн.....	6
Хүснэгт 3. Барилга байгууламж .....	8
Хүснэгт 4. БОНБНҮГ-ээр тогтоосон төслийн гол ба болзошгүй нөлөөлөл .....	15
Хүснэгт 5. Уурхайн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	19
Хүснэгт 6. 2023 оны нөхөн сэргээлтийн төлөвлөгөө .....	22
Хүснэгт 7. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө.....	23
Хүснэгт 8. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө .....	26
Хүснэгт 9. Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө .....	27
Хүснэгт 10. Уурхайн хог хаягдлын зохицуулалтын төлөвлөсөн арга хэмжээ .....	30
Хүснэгт 11. Байгаль орчны хяналт шинжилгээний зөврийн багажууд.....	34
Хүснэгт 12. ....	35
Хүснэгт 13. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	39
Хүснэгт 14. БОМТ-2023 хэрэгжилтийг тайлагнах хуваарь .....	41
Хүснэгт 15. БОМТ-2023 хэрэгжилтэд төлөвлөсөн зардал.....	42

# 1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

## 1.1. Оршил

“Энхтунх Орчлон” ХХК нь Австралийн хөрөнгө оруулалттай Терра Энержи ХХК-ийн харилцан хамаарал бүхий компаниуд юм. “Терра Энержи” ХХК нь Сингапурын хөрөнгийн биржид бүртгэлтэй уул уурхайн компани болох “Бридж Ресурсэс” компаний дийлэнх хувийн эзэмшилд байдаг компани юм.

“Энхтунх Орчлон” ХХК нь 2020 оны 3-р сард MV-019149 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайд уурхайн өргөтгөл хийж, мөн улсын комисст хүлээлгэн өгч ашиглалтанд оруулсан.

“Энхтунх Орчлон” ХХК-ийн “Хар Сэрвэгэн” нүүрсний орд ашиглах төслийн гол зорилго нь уул уурхайн салбарт амжилттай ажиллан, Монгол улсын эдийн засгийн өсөлтөнд хувь нэмэр оруулах, ашиглалт, үйлдвэрлэлийн шинэ техник технологийг нэвтрүүлэх, орон нутгийн хөгжилд эерэг нөлөө үзүүлэх, орон нутгийн ард иргэдийг ажлын байраар хангах, нүүрсний ордын талбайд ашигт малтмалын хайгуул олборлолтын ажлыг чанарын өндөр түвшинд, үнэн зөв тогтоон гүйцэтгэж, ашиглалтын явцад байгаль орчинд ээлтэй, хаягдал багатай техник, технологи, тоног төхөөрөмжөөр харилцан ашигтай үйл ажиллагаа явуулах, орон нутгийн төсөвт тодорхой хэмжээний орлого оруулах зэрэгт энэхүү төслийн зорилго оршино.

## Уурхайн олборлотын төлөвлөгөө

“Энхтунх Орчлон” ХХК нь “Хар сэрвэгэн” уурхайгаас 2023 онд нийт 149346 м3 шимт хөрс, 8,713,771 м3 хөрс хуулж, 747,931 тонн нүүрс олборлож нийт 9,248,007 м3 уулын цулын ажлыг гүйцэтгэхээр уулын ажлын төлөвлөгөөнд тусгаж, эрх бүхий байгууллагаар батлуулсан.

## 1.2. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж байгууллагын мэдээлэл

“Хар Сэрвэгэн” нэртэй MV-019149 дугаартай ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг эзэмшигч “Энхтунх Орчлон” ХХК-иуд нь Австрали улсын хөрөнгө оруулалттай, “Терра энержи” (улсын бүртгэлийн дугаар 9011221028) ХХК-ний охин компани юм.

Хүснэгт 1. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжийн тухай мэдээлэл

Аж ахуйн нэгжийн нэр	“Энхтунх Орчлон” ХХК
Улсын бүртгэлийн дугаар	9019077039
Регистрийн дугаар	5618339
Үйл ажиллагааны чиглэл	Гадаад худалдаа, ашигт малтмалын хайгуул
Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл	MV-019149
Хаяг	Монгол улс, Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Нарны зам 91, “Санроуд оффис” төвийн 6-р давхар
Утас	(+976) 75750915
Факс	(+976) 7010-1092


## 1.3. Төслийн байршил

Хар Сэрвэгэн нүүрсний орд нь Өмнөговь аймгийн Ноён сумын нутагт Ноён сумын төвөөс зүүн урагш 25 км, Өмнөговь аймгийн төв Даланзадгад сумаас 220 км, Улаанбаатар хотоос 800 км зайд оршдог.

Хар Сэрвэгэн нүүрсний орд нь Монгол улсын дэд бүтэц сул хөгжсөн бүс нутагт байрлаж байгаа боловч сүүлийн жилүүдэд тухайн бүс нутагт ашигт малтмалын эрэл, хайгуулын ажил эрчимжиж, дэлхийд тэргүүлэх томоохон алт, зэс, нүүрс, жоншны ордууд илэрч байгаа нь цаашид эдийн засаг, дэд бүтцийн гол бүс нутаг болох нь тодорхой юм. Засаг захиргааны хувьд талбай нь Ноён сумын нутагт харьяалагддаг. Тусгай зөвшөөрлийн булангийн цэгүүдийг дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 2. Тусгай зөвшөөрөлтэй талбайн өнцгийн солбилцолууд - Хар Сэрвэгэн

№	Уртраг	Өргөрөг	№	Уртраг	Өргөрөг
1	E 102° 15' 32.86"	N 43° 8' 27.35"	6	E 102° 19' 21.38"	N 43° 7' 1.31"
2	E 102° 16' 9.42"	N 43° 7' 46.49"	7	E 102° 16' 0.8"	N 43° 7' 1.31"
3	E 102° 16' 59.43"	N 43° 8' 5.75"	8	E 102° 16' 0.79"	N 43° 3' 44.88"
4	E 102° 16' 34.84"	N 43° 8' 27.31"	9	E 102° 11' 16.66"	N 43° 3' 44.88"
5	E 102° 19' 21.44"	N 43° 8' 27.26"	10	E 102° 11' 16.66"	N 43° 8' 27.36"



Зураг 1. Ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайн байршил

#### 1.4. Ордын судалгааны түүх

“Энхтунх Орчлон” ХХК нь 2008-2011 оны хооронд 12600Х хайгуулын тусгай зөвшөөрөлтэй талбайг эзэмшиж байсан БНХАУ-ын хөрөнгө оруулалттай “Хуа Сэн Нан Юан Юу Шэ Зерен” компани нь эрэл-хайгуулын зорилготойгоор хайгуулын талбайн баруун, зүүн өмнөд болон өмнөд хэсгээр нийтдээ 5250 тууш метр, 50 ширхэг кернтэй алмазан өрөмдлөгийн цооног өрөмдсөн байдаг. 2012 онд “Энх Тунх Орчлон” компани тус талбайд хайгуулын ажил хийх эрхийг хууль ёсны дагуу шилжүүлэн авсан.

#### 1.5. Уурхайн барилга байгууламж

“Цагаан өвөлжөө”, “Энхтунх орчлон” ХХК-иуд нь “Терра энержи” ХХК-ийн охин компаниуд бөгөөд Баруун ноён уул, Хар сэрвэгэн уурхайнууд нь нэг ордод үйл ажиллагаа явуулж байгаа нэг уурхай учраас уурхайн бүх барилга байгууламж, дэд бүтцийг нэгдмэл байдлаар ашигладаг. Уурхайн хөрс хуулалтын ажил эхэлэхийн өмнө бид холбогдох хууль дүрэм журамд заасны дагуу зохих зөвшөөрлүүдийг авч, Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг мэрэгжлийн байгууллагаар гүйцэтгүүлж БОНХЯ-аар батлуулан уурхайн барилга байгууламжуудыг барьж байгуулсан. Үүнд: Уурхайн ажиллагсадын хотхон ил уурхай талбайгаас баруун тийш 3 км орчим зайд байрлуулсан байна. Хотхоны бохир ус цэвэрлэх байгууламж бариж ашиглалтан оруулсан бөгөөд 2013-2014 онд нүүрс ачиж буулгах гаалийн хяналтын талбай, уурхайн хүнд механизмын засварын газар, оффис, шатахуун түгээх станц, тэсэрч дэлбэрэх материалын агуулах, уурхайн шүүрлийн ус тунгаан шүүж цэвэршүүлэх далан зэргийг барьж байгуулан үйл ажиллагаагаа өнөөг хүртэл явуулж байна.

Хүснэгт 3. Барилга байгууламж

№	Барилга байгууламж	Бүрэлдэхүүн	Хүчин чадал
1	Ажилчдын хотхон	Гэр	450 хүн
2	Засварын төв		1470 м <sup>2</sup>
3	Уурхайн оффис		344 м <sup>2</sup>
4	Лаборатори	Дээж бэлтгэлийн байр	112 м <sup>2</sup>
		Шинжилгээний лаборатори	139 м <sup>2</sup>
5	Гаалийн хяналтын талбай	Гаалийн хяналтын оффис	60 м <sup>2</sup>
		Пүү хянагчийн байр	150 тонн
6	Тэсрэх материалын агуулах		80 тонн
7	Бохир ус цэвэрлэх байгууламж		250 хүний ахуйн ус
8	Шатахуун түгээх станц		100 тонн

**Уурхайн кэмп:** Одоогийн байдлаар уурхайн нийт ажилчид түр кэмп буюу ойролцоогоор 450 хүн амьдрах 111 ширхэг гэрт амьдарч, байрлаж байна.

**Хяналт шинжилгээний лаборатори:** Баруун ноён уул 1 нүүрсний ордын ил уурхайн талбайн ойролцоо хяналт шинжилгээний лабораторийг ашигладаг. Энэхүү лаборатори нь 20 тн-ийн 3 ширхэг контейнер байх ба контейнерийг лабораторийн зориулалтаар иж бүрэн тоногдсон байна. Хяналт, шинжилгээний лаборатори нь ил уурхайн олборлосон болон нүүрсний дээжүүдийг хүлээн авч нүүрсний шинж чанарыг тодорхойлох үүрэгтэй байна. Иж бүрэн тохижилттой лабораторийн гадна талаар ойролцоогоор 15x10x3.5 метрийн хэмжээтэйгээр хаалт буюу байгууламж барина.

**Уурхайн оффис:** Уурхайн оффис нь мөн кэмийн төлөвлөлтөд багтсан ба нийт 90 м<sup>2</sup> талбайг эзэлнэ. Оффисын байр нь хүлээн авагчийн хэсэг, оффисын талбай, уулзалтын өрөө, санхүүгийн өрөө, ерөнхий менежерийн өрөө гэсэн хэсгүүдээс тогтоно. Оффис нь кэмийн цогцолбор барилгын хоёрдугаар давхарт байхаар зураг төсөлд тусгагдлаа.

**Уурхайн түр гал тогоо болон угаалгын газар:** Уурхайн түр гал тогоо нь кэмийн талбай дотор байрлах ба ойролцоогоор нэг дор 60-70 хүн хүлээж авах хүчин чадалтай, сэндчичэн материалаар хийгдсэн 375м<sup>2</sup> талбайтай байгууламж юм.

**Соёл амралтын байр:** Төсөл хэрэгжүүлэгч нь ажилчдын тав тухыг хангах болон чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх үүднээс уурхайн кэмп соёл амралтын байрыг сайжруулахаар ажиллаж байна. Соёл амралтын байранд ТВ өрөө болон чийрэгжүүлэх амралтын өрөөнүүдийг шинээр байгуулна.

**Цэвэрлэх байгууламж:** “Баруун ноён уул-1” уурхайн кэмпээс зүүн тийш 150м зайд

байрладаг бохир ус цэвэршүүлэх байгууламжийг НБИК Нойон компаниар бариулсан байна. Энэхүү бохир ус цэвэрлэх байгууламжийн ашиглаж байгаа технологи нь SBR буюу биологийн агааржуулах систем (тусгай нян)-ийг ашиглан бохир усыг байгаль орчинд хор нөлөөгүй цэвэршүүлдэг. Уурхайн кэмпээс үүссэн бохир усыг хоолойгоор, оффисоос үүссэн бохир усыг машинаар тээвэрлэн цэвэршүүлэх байгууламжид нийлүүлдэг. Бохир ус цэвэршүүлэх байгууламж нь хоногт 50 м<sup>3</sup> бохир ус цэвэршүүлэх хүчин чадалтай байна.

**Шатахуун хадгалах агуулах:** Уурхайн шатахуун хадгалах агуулахын эзэмшигч, зураг төсөл боловсруулагч, барилгын ажил гүйцэтгэгч компаниар “М-Ойл групп” ХХК ажиллаж байгаа бөгөөд 650м<sup>3</sup> багтаамжтай, агуулахын нийт барилга байгууламж 1.5 га талбайтай байхаар төлөвлөсөн байна. Уг агуулахад дизель түлш хадгалах бөгөөд энэ нь газрын тосны бүтээгдэхүүний ангиллаар II-р ангилалд (28-450с хэмд гал авалцах) хамаарах хялбар асах бүтээгдэхүүнүүд юм.

Шатахуун нийлүүлэх гэрээт компаниар “Гурван Зам” ХХК-ийг урьдчилсан байдлаар сонгосон. “Гурван Зам” ХХК нь Өмнөговь аймагт болон Гурван Тэс суманд салбартай бүс нутгийн түлшний нийлүүлэлтийг хийдэг туршлагатай компани юм.

**Засварын цех:** Засварын газрыг кэмпээс ил уурхайруу хүрэх замын дунд байрлуулахаар төлөвлөсөн. Засварын газрын талбайн орчимд ажлын байр, бутлуур болон нүүрс жинлэх хэсгийг байгуулах ба засварын газрын ойролцоо агуулах, шатахуун түгээгүүрийн станц зэрэг байрлана. Уурхайд байгуулж ашиглалтанд оруулсан 1470 м<sup>2</sup> талбай бүхий засварын төвийг ашиглаж байна.

Төсөл хэрэгжүүлэгч “Энхтунх орчлон” ХХК нь “Цагаан өвөлжөө” ХХК-ний “Баруун Ноён Уул-1” нэртэй уурхайд ашиглагдаж байгаа ажилчдын кемп, засварын газар, захиргааны байр, баяжуулах үйлдвэр, гадаад тээврийн зам, бусад дэд бүтцийг ашиглахаар төлөвлөсөн байна. Иймд төслийн талбайд дэд бүтцийн барилга байгууламжууд баригдахгүй бөгөөд ил уурхай, хаягдлын овоолго, нүүрсний хадгалах талбай, зам, шимт хөрсний овоолгын байгууламж тус тус байгуулсан.

## 1.6. Уурхайн дэд бүтэц

**Цахилгаан, дулаан хангамжийн эх үүсвэр шугам сүлжээ:** Баруун ноён уулын уурхай дээр одоогийн байдлаар төвлөрсөн цахилгаан сүлжээнд холбогдоогүй ба одоогийн ажиллаж байгаа хэрэглээний цахилгааныг “Cummins”, “ULE”, “Teksan”, “Weifang Changshig” зэрэг нэр төрлийн дизель генераторууд хэрэглэн хангадаг. Одоогийн ажиллаж байгаа дизель генераторуудын суурилагдсан нийт хүчин чадал нь 1200 кВт.



**Ил уурхайн гэрэлтүүлэг:** Ил уурхай болон овоолгод ашиглаж буй зөөврийн гэрэлтүүлэг болох Night-Lite NL6 зөөврийн гэрэлт цамхаг нь 4 ширхэг 1,000 ватт метал галид ламптай ба 110'000 люмен гэрэлтүүлгийн хүрээ бүхий тод цагаан гэрэл гаргана. Шинэ төрлийн хаалганууд нь нягт, зэвэрдэггүй материалаар хийгдсэн ба бүхий л гол гол сервис үйлчилгээг хийх боломжтой. Гэрэлтүүлгийн 4 тулгуурт тогтворжуулагч нь 100 хүртэл км/ц хурдтай салхийг тэсвэрлэх чадвартай. Катерпилларын 1800 моторын эргэлт бүхий хөдөлгүүрээр ажилладаг.

**Ус хангамж:** Баруун ноён уул-1 нүүрсний уурхайн эдэлбэрт усны хайгуул судалгааны “Акватера” ХХК-аар 2013 онд Өмнөговь аймгийн Ноён сумын Ганзагад багийн нутагт гидрогеологийн анхан шатны судалгаа хийлгэсэн. Энэ ажлын хүрээнд нийт 7ш гидрогеологийн хайгуулын цооног өрөмдсөн бөгөөд үүний дараа ил уурхайн усжилтын тооцоог “Цэнхэр-Эрдэнэ” ХХК хийсэн. Улмаар 2018 онд уурхайн усжилтыг нарийвчлан тогтоох зорилгоор гидрогеологийн судалгааны ажлыг “ОХЬ УС” ХХК боловсруулсан. Мөн “Ундрага Өмнөговь” ХХК нь 2013 оны 5 сард унд-ахуйн усанд зориулж уурхайн кэмгийн ойролцоо гүний худаг өрөмдөж унд-ахуйн усны хэрэгцээг хангах усны эх үүсвэрийг тогтоосон байна. Уурхайн кэмгийн унд-ахуйн усны хэрэгцээнд шаардлагатай усыг гүний худгаас хангадаг ба ажилчдын өдөр бүрийн хэрэглээнд савлагаатай цэвэр усыг ажилчдын хүссэн хэрэглээгээр нь өгч үйлчилдэг. Гүний худаг нь уурхайн кемпээс зүүн зүгт (N-43°01'08.6'', E-101°17'39.4'', ELV-1553) байрлана. Харин бусад хэрэгцээний усыг уурхайн шүүрлийн усан санд тунгаасан уснаас соруулан авч ашиглана.

**Шүүрлийн ус зайлуулалт:** Уулын малталтууд руу нэвчин орж ирэх усыг сувгаар дамжуулан зумпэнд хуримтлуулан насосоор шавхан зайлуулна.

Энэхүү усыг нэвтрэх шатлал бүрт байгуулах зумфны багтаамжаас хугацааны тохируулгатай насосоор шавхан зайлуулна. Зумпэнд хуримтлуулсан шүүрэлтийн усыг даланруу насосоор татаж, ил уурхайн зам усалгаа болон техникийн усны хэрэглээнд ашиглахаар төсөлд тусгалаа. Одоогийн байдлаар ил уурхайд дизель генератортай Sykes болон Godwin брэндийн насосуудыг ашиглаж байна.

**Харилцаа холбоо:**

Уурхайн талбайд хиймэл дагуулын антенн суурилуулж интернэт ашиглаж байгаа бөгөөд интернэт суурин утасаар холбогдож байна.

**Зам харилцаа:**

Зам харилцааны хувьд Улаанбаатар хотоос баруун урагш Өмнөговь аймгийн Баяндалай сум хүртэл 440 км засмал замтай, Цогт-Овоо сумаас Өмнөговь аймгийн төв хүртэл 130 км

сайжруулсан шороон замтай, аймгийн төвөөс Ноён сум хүртэл 220 км-т орших бөгөөд тээврийн үндсэн төрөл автомашин, аймаг, сум, баг, хилийн дагуух суурин газрууд нь орон нутгийн шороон замаар холбогддог.

Орд нь дэд бүтэц хөгжиж буй бүс нутагт хамаарагдах бөгөөд хамгийн ойрхон хилийн боомт баруун урагш Өмнөговь аймгийн Гурван тэс сумын Шивээ хүрэнгийн боомт хүртэл 140 км бөгөөд “Баруун ноён уул-1”-ын нүүрсний уурхайгаас Нарийн сухайт-Шивээ хүрэн чиглэлийн авто замын 98.4км, 2 зурвастай, улсын чанартай, орон нутгийн замын Техник эдийн засгийн үндэслэлийг “Эн Би Си Си” ХХК-аар 2013 онд хийлгэж, Зам тээврийн сайдын 2013 оны 05 дугаар сарын 06 –ны өдрийн 106 дугаар тушаалын хавсралтад заасан солбилцлын дагуу батлагдсан.

## **2. ТӨСӨЛ ХЭРЭГГИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

### **Уур амьсгал:**

Ноён ба Гурвантэс сумын агаарын температурын жилийн явц төсөөтэй боловч XI-III сард Ноён сумын нутаг Гурвантэс сумын нутгаас  $1.6-0.9^{\circ}\text{C}$  –ээр хүйтэн, IV-X сард  $1.2-2.7^{\circ}\text{C}$  –ээр дулаан болно. Ноён ба Гурвантэс сумын нутаг дэвсгэрийн агаарын температурын сүүлийн таван жилийн дундажийг олон жилийн дундажтай (1971-2010) харьцуулахад зуны улиралд олон жилийн дунджаас  $1.0-1.4^{\circ}\text{C}$ -ээр дулаарч, харин өвлийн саруудад  $0.6-1.6^{\circ}\text{C}$ -ээр хүйтрэх магадлалтай болно.

Ноён, Гурвантэс сумдын нутаг дэвсгэр дээр өвлийн улиралд (XII-I сар) цацрагын хэмжээ бага  $229-317$  мДж/м<sup>2</sup>, V сард хамгийн их буюу  $650-680$  мДж/м<sup>2</sup> болно. Ноён сумын нутаг дэвсгэр дээр тусах нарны нийлбэр цацрагийн ерөнхий горим Гурвантэс сумынхтай бараг ижил зүй тогтолтой гэж үзэж болно.

Ноён, Гурвантэс сумын нутаг дэвсгэр дээр олон жилийн дундажаар хамгийн ихдээ  $126$  мм, хамгийн багадаа  $51.2$  мм, ердийн дундажаар  $90-95,0$  мм тунадас унадаг, нийт хур тунадасны  $68-93\%$  -нь дулааны улиралд унана .

Гурвантэс, Ноён сумын бүс нутагт харьцангуй чийгийн жилийн дундаж  $38.1\%$  байдаг бол,  $30\%$  -с бага чийгтэй өдрийн тоо жилд дунджаар  $85-89$  хоног байна.

Ноён сумын нутаг дэвсгэр дээрх салхины чиглэлийн давтагдал нь жилийн туршид төдийгүй, салхи ихтэй хаврын улиралд ч нэгэн адил баруун, баруун хойд, баруун өмнө зүгийн салхи зонхилж, тус бүр нийт тохиолдлын  $20$  гаруй хувийг эзэлнэ. Харин зуны улиралд баруун хойд ба баруун өмнө зүгийн салхины давтагдал тус бүр  $16-19\%$ , баруун зүгийн салхи  $15\%$ -ийг эзэлнэ. Гэхдээ зуны улиралд зүүн хойд, зүүн өмнө зүгийн салхи  $10\%$ -аас доошгүй, зүүн зүгийн салхи  $7-9\%$ -ийг эзэлдэг магадлал их юм

### **Хөрсөн бүрхэвч:**

Цөлийн сайрын сайр чулуурхаг бор саарал хөрс, элсэн хуримтлал, жалга сайрын сул хөгжилт хөрс, цөлийн бор саарал хөрс, толгодын заримдаг цөлийн чулуурхаг нимгэн бор хөрс тархах бөгөөд төрлийн хэмжээнд ялгарч, алаг цоог тархана.

Олборлолт явуулах талбайн хэмжээнд Заримдаг цөлийн Цайвар бор хөрс тархах бөгөөд хуурай сайраар их хэрчигдсэн өмнөт хэсэгт нь Цөлийн Бор саарал хэв шинжийн хөрс, тэдгээрийн чулуурхаг, сайргархаг, ердийн, мараалаг, элсэн хучаастай, сайрын зэрэг төрлийн

хөрс зонхилон тогтворжсон байна.Талбайн хэмжээнд тогтворжсон эдгээр хөрс элсэн болон элсэнцэр голдуу ширхэгийн бүрэлдэхүүнтэй, маш бага хэмжээний ялзмаг агуулсан үржил шимээр тааруу, шүлтлэг уусмалын орчинтой, хөрсөнд хужирлаг шинж чанар давамгайлж байна. Хөрсний байгалийн аясаар нөхөн сэргээгдэх чадвар удаан, элэгдэл эвдрэлд өртөмтгий, элсэн-сайр чулуун хучаас ярагдсан тохиолдолд хөрсний эвдрэл идэвхжихээр байна. Иймд сөрөг нөлөөллийг бууруулан ажиллах шаардлагатай.

### **Ургамлан нөмрөг:**

Уурхайн эргэн тойронд ургамал нөмрөг харьцангуй тогтвортой, жилийн дөрвөн улиралд ашиглаж буй бэлчээрийн нутаг. Ургамлын арвийн үнэлгээний хувьд зонхилогч, дэд зонхилогч ургамлууд нь *сop1-sp*, бусад зүйл ургамлууд нь *sp* цөөн хэдэн зүйл ургамал нь *solарвийн* үнэлгээтэй байна.Ургамлын дундаж өндрийн хувьд олон наст өвслөг ургамал-5.5см, сөөглөг ба сөөгөнцөр ургамал-21.3см. Ургац 97.5-112.5 кг/га.

Ургамлын ташинга үүсгэх байдлаар нь үзвэл сөөглөг ба сөөгөнцөр ургамал дээд дэд, олон наст өвслөг ургамал дунд дээд, ганц ба хоёр наст ургамлын өнгөрсөн жилийн босоо хагд (найлзуурууд) доод дэд ташингийг бүрдүүлж байна.

Талбайн өнгөн хөрсийг хуулж овоолго үүсгэн техникийн нөлөөлөлд өртсөн талбайг нөхөн сэргээхэд ашиглах, нөхөн сэргээх үйл ажиллагааг цаг алдалгүй хийж ургамалжуулах арга хэмжээ авах нь байгаль орчноо хамгаалах нөхөн сэргээх үйл ажиллагаа бөгөөд тоосжилтыг бууруулж, ажилчдын ажиллах таатай нөхцөл, эрүүл орчинг бүрдүүлэх сайн талтай. Мөн Бэлчээр тэжээлийн үнэт ургамлуудыг хамгаалах, тэдгээр ургамлыг тарих, нөхөн сэргээх ажлыг мэргэжлийн байгууллагаар өндөр түвшинд гүйцэтгүүлэх шаардлагатай.

### **Амьтаны аймаг:**

Өмнөговь аймаг Төв Азийн их говь цөлийн бүсэл оршино. Ноён сумын нутагт хамаарах бөгөөд амьтны газарзүйн мужлалын хувьд Алтайн өвөр говийн тойхргт хамаарах (А.Г.Банников 1954) бөгөөд Эрдэнэ нурууны салбар уулсаас өмнө зүгт чиглэсэн сайр садаргаар ихээхэн хэрчигдсэн харгана, буйлст хайрга чулуурхаг, зарим хэсэгт хужир мараа бүхий дэрс, түнгэт хотгортой хур тунадас элбэг үед ус ундрагатай, гов цөлийн амьтад байршин нутаглах нэн тохиромжтой нутаг юм. Иймдээ ч говь цөлийн бүсийн амьтны аймгийн түлхүүр зүйл болох олон улсын болон бүс нутгийн хувьд ховор нандин зүйлүүд олон байдгаараа онцлог юм.

Төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт нөлөөлөх сөрөг нөлөөллийг тогтоох хяналтын ажлыг улирал тус бүрт зохион байгуулах, хяналтын явцад илэрсэн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлж байх шаардлагатай. Мөн төслийн явцад амьтдын амьдрах орчин өөрчлөгдөж, шинээр бий болсон орчинд тухайн нутагт өмнө нь

тохиолдож байгаагүй, эсвэл тоо толгой нь цөөн байсан амьтад олноор шилжин суурьшиж болзошгүй тул уурхайн ашиглалтаас гарсан талбайд нэн даруй нөхөн сэргээх ажлыг зохион байгуулж байх шаардлагатай.

**Гадаргын болон гүний ус:**

Уурхайн хана, мөргөцөгт шүүрэн орж ирэх усны тоо хэмжээг усны статик нөөцийн хэсэгт тооцоолсноор цагт 78.1м<sup>3</sup> байх бөгөөд Уртын голын Сайр дагасан газрын доорхи усны урсацын дагуу ул суурийн хадархаг чулуулгийн ан цавын ус, сайрын хөрсний нүх сүвийн ус нийлж, нэгдсэн нэг урсацыг бүрдүүлснээр ил уурхайн олборлолтыг нөхцөлд уурхайн хана, ёроолын мөргөцөгт шүүрэн орж ирэх усны тоо хэмжээ улам ихэсгэх зүй тогтолтой нь ажиглагдсан байна. Усны байгалийн статик нөөцийг тооцоолсон тооцооллоос үзэхэд хоногт 1875.2м<sup>3</sup> ус шүүрэх бөгөөд үүнээс 93.12м<sup>3</sup>-г нөхөн сэлбэгдэнэ гэж тооцвол ашиглалтын хугацаанд 2940432м<sup>3</sup>-г усыг гадагшлуулах бөгөөд газрын доорхи усны статик нөөцийн барагдалт 38.4% орчим байна. Энэ нь газрын доорхи усны статик нөөцийн ашиглалтын хувь (доль)-0.3-0.5-аас хэтрэхгүй байх нөхцлийг бүрэн хангаж байна.

Гадаргын усны болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлж, горхи булаг ширгэх, мөн айлуудын худаг дээр мониторинг хийж ажиллах нь зүйтэй. Төслийн талбайн эргэн тойронд газрын доорхи усны тархалтын ерөнхий зүй тогтлыг судалж, ус хагалбарын бүс, ус хуримтлалын мужуудыг нарийвчлан тогтоох шаардлагатай.

**Тусгай хамгаалалттай газар нутаг, түүх соёлын өв:**

Түүх соёлын дурсгалт зүйлс, ТХГН-т төслөөс үзүүлэх нөлөө дунд зэрэг юм. Өмнөговь аймгийн Ноён сумын нутагт орших MV-017162, MV-019149 тоот тусгай зөвшөөрөлтэй талбайнууд нь нь Засгийнгазрын 2012 оны 194-р тогтоолоор баталсан усан сан бүхий газрын хамгаалалтын бүстэй давхцалгүй байна. Иймд төслийн хэрэгжилтийн үед ТХГН-д нөлөөлөх нөлөөлөл байхгүй юм. Харин тусгай зөвшөөрөл бүхий талбайнуудад хийсэн археологийн судалгаагаар түүх, соёлын дурсгалт зүйл 5 ш тодорхойлогдсоныг авран хамгаалах ажлыг Шинжлэх Ухааны Академийн Түүх Археологийн хүрээлэнгийн эрдэмтэд судлаачидтай хамтран гүйцэтгэсэн.Цаашид төслийн үйл ажиллагааны үед түүх дурсгалт зүйлс илэрвэл соёлын өвийг авран хамгаалах арга хэмжээг авах хэрэгтэй.

### 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧООН

“Баруун Ноён Уул-1”, “Хар сэрвэгэн” ордуудын нүүрс олборлох төслийн БОНБНҮ-ээр төслийн гол болон болзошгүй нөлөөллийг дараах байдлаар тодорхойлсон байдаг.

Хүснэгт 4. БОНБНҮ1-ээр тогтоосон төслийн гол ба болзошгүй нөлөөлөл

№	Байгаль орчны үзүүлэлт	Шууд	Шууд бус	Өөрөө зохицуулагдах	Богино хугацааны	Урт хугацааны	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Сулавтар нөлөөлөх	Дунд зэрэг нөлөөлөх	Хүчтэй нөлөөлөх
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
<b>1. Байгалийн төрөл зүйн өөрчлөлт</b>											
1	Газрын доорхи урсацын өөрчлөлт	-				-		-			-
2	Газрын доорхи усны чанарын өөрчлөлт		-	-		-		-	-		
3	Ургамлын бүтцийн өөрчлөлт		-			-		-		-	
4	Хөрсний элэгдэл, эвдрэл	-				-		-		-	
5	Геологийн тогтоцын өөрчлөлт	-		-		-		-			
6	Зэрлэг, ан амьтдын орон зайн өөрчлөлт		-	-		-		-	-		
7	Уур амьсгалын (бичил) өөрчлөлт										
<b>2. Байгалийн нөөцийн ашиглалт</b>											
8	Газрын гадаргын нөөц баялаг	-				-		-		-	
9	Бэлчээр, тэжээлийн байдал	-				-		-		-	
10	Эрдэс түүхий эд, нөөц	-				-		-			-
11	Эрчим хүчний нөөц		-	-							
<b>3. Байгаль орчны чанарын өөрчлөлт</b>											
12	Ундны усны чанар өөрчлөгдөх		-		-		-			-	
13	Ундны усны нөөц хомстох	-				-		-			-
14	Агаарын бохирдол	-		-		-		-		-	
15	Хөрсний бохирдол		-		-		-			-	
16	Хорт бодис усаар дамжин хүн, амьтанд үзүүлэх нөлөөлөл		-			-		-	-		
17	Дуу, чимээ шуугианы нөлөөлөл	-			-		-		-		

<b>4. Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палентологийн олдвор</b>											
18	Байгалийн үзэсгэлэнт төрх өөрчлөгдөх	-				-		-	-		
19	Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх	-				-	-			-	
20	Тусгай хамгаалалттай газар, нутагт нөлөөлөх										
21	Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх										
22	Археологи, палентологийн олдворт нөлөөлөх										
<b>5. Нийгэмд үзүүлэх нөлөөлөл</b>											
23	Дэд бүтцийн хөгжилд нөлөөлөх	+				+		+		+	
24	Үйлчилгээний салбарын үйл ажиллагаанд нөлөөлөх	+				+		+	+		
25	Хүн амын орлого нэмэгдэж өөрчлөгдөх	+			+			+		+	
26	Хүн амын тоо өөрчлөгдөх		+			+		+	+		
<b>6. Эдийн засаг, байгаль орчин</b>											
27	Хувийн өмчийн болон татварын орлого өөрчлөгдөх	+		+	+			+		+	
28	Орон нутгийн орлого нэмэгдэх	+		+		+		+		+	
29	Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох		+		+		+		+		
30	Ажлын байр нэмэгдэх	+				+		+			+
31	Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх		+	+		+	+		+		
32	Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх		-			-		-		-	
<b>7. Бусад нөлөөлөл</b>											
33	Шороон зам харилцаа, машин механизмын хөдөлгөөн шилжилтээс үүдэх хөрсний эвдрэл	-				-	-			-	
34	Ахуйн бохир ус, нефтийн бүтээгдэхүүн хөрсөнд нэвчиж хөрс ба грунтны усыг бохирдуулах.		-			-		-	-		
35	Ахуйн хог, хаягдал, хогийн цэгийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах, шавьж үржих	-			-		-		-		
36	Хүчтэй салхи, тоосжилт		-	-	-					-	
<b>Нөлөөллийн тоо ширхэг</b>	Сөрөг	13	10	6	6	15	10	11	8	9	3
	Эерэг	6	3	3	3	6	2	7	4	4	1

## 4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай шинэчилсэн хуулийн 9-р зүйлд зааснаар Байгаль орчны менежмент төлөвлөгөө (БОМТ) нь нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалал хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан баримт бичиг бөгөөд Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ (БОННУ)-ний салшгүй хэсэг юм. “Баруун Ноён Уул-1” нүүрсний ордыг ил аргаар ашиглах төслийн БОМТ-г Монгол Улсын байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай шинэчилсэн хууль, БОНХЯ-ны сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний А/618 дугаар тушаалын дагуу холбогдох дүрэм журмын шаардлагад нийцүүлж боловсруулав.

Бид уурхайн төслийг хэрэгжүүлэхдээ 2023 онд төслийн бүхий л үйл ажиллагааны үе шат тус бүрт байгаль орчинд учирч болох сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, байгалийн баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх ажилд нэн тэргүүний ач холбогдол өгч, дараах эрхэм зорилтуудыг баримтлан ажиллана.

### БОМТ-2023 зорилт


#### БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛТУУД

- Монгол улсын холбогдох хууль тогтоомжуудын хэрэгжилтийг сайжруулах;
- Нутгийн ард иргэдийн уламжлагдаж ирсэн соёл, өв уламжлалыг хүндэтгэж хамгаалах;
- Батлагдсан БОМТ 2023-г хамгийн багадаа 90% -ийн гүйцэтгэлтэйгээр хэрэгжүүлэх;
- Хүрээлэн буй орчны талаар ажилтнуудын мэдлэгийг дээшлүүлэх;
- Байгаль орчны мэргэжилтнүүдийн нэмэгдүүлэх;
- Төрийн захиргааны байгууллагууд болон нутгийн өөрөө удирдах байгууллагуудын хяналт шалгалт, БО-ны аудитаас гарах зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх;



### Хамрах хүрээ:

Энэхүү Энхтунх Орчлон ХХК-ийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг залгаа орших “Цагаан Өвөлжөө” ХХК-ийн MV-017162 тусгай зөвшөөрлийн талбайн “Баруун Ноён Уул” нүүрсний төслийн бүхий л үйл ажиллагаанд баримтлан ажиллана.



Зураг 2. Хамрах хүрээ

## 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 5. Уурхайн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Чиглэл	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төгрөг	Тоо хэмжээ	Хэрэгжүүлэх давтамж	Нийт зардал, төгрөг	Баримтлах хууль, журам стандарт
1	Агаарын чанар	Уурхайн үйл ажиллагааны үе шатанд замын гадаргуу болон уурхайн орчны тоосжилт их босдог газруудыг уурхайн ухлагаас гарч байгаа шүүрлийн усыг ашиглан услах, тоосжилт дарах	Төслийн үйл ажиллагааны хэмжээнд	Нэгж усалгаа	0	тодорхой лоогүй	Жилийн турш	“Баруун ноён уул” уурхайн Шүүрлийн ус ашиглана.	“Агаарын тухай”, “Автозамын тухай”, “Хог хаягдалын тухай” хууль, MNS 5885:2008, MNS 0012-013:1991, MNS 4585:1998, БОНБНУ, дотоод журмууд
		Дотоод орчны агаарын чанарын хэмжилтийг албан байр, талбай дээр ажиллаж байгаа машин техникийн кабин, ажилчдын гэр дотор хийх. /Хэмжилтийн үр дүн MNS 4990:2015 стандарт/	Уурхайн талбай дээр ажиллаж байгаа бүх төрлийн машин техник	Нэгж хэмжилт	0	4	Улирал бүр	“Баруун ноён уул” уурхайн БОМТ-ын төсөвт тусгасан	

2	Гадаргын болон газрын доорх	Шүүрлийн усны хэрэглээний бүртгэл хийх	Төслийн үйл ажиллагааны хэмжээнд	Нэгж тайлан	166,666	12	Сар бүр	2,000,000	MNS5916:2008, MNS 3297:1991, БОНБУ, дотоод журмууд
		Унд ахуйн усны хэрэглээг зөв зохистой ашиглах талаар ажилчидад сургалт орох	Төслийн талбайн хэмжээнд	м <sup>3</sup>	-	-	Жилийн турш	100,000	
3	Хөрсөн бүрхэвч	Орон нутгийн зам болон уурхайн бүс орчимд олон салаа зам гаргаж хөрс талхлагдахаас сэргийлж жолооч нарт давтан зааварчилгаа өгөх	Уурхай-Сумын төвийн чиглэл	хүн	-	-	6 сар тутамд	Дотоод зардлаар	“Ашигт малтмалын тухай”, “Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай”, “Химийн хорт аюултай бодисийн тухай” хууль, MNS5916:2008, MNS 3297:1991, БОНБУ, дотоод журмууд
		Хөрс бохирдуулагч хөрсөнд алдагдсан тохиолдол бүрт саармагжуулах, цэвэрлэх арга хэмжээ авах	Төслийн талбайн хэмжээнд	м <sup>3</sup>	-	Төлөвлөх боломжгүй	Жилийн турш	“Баруун ноён уул” уурхайн БОМТ-ын төсөвт тусгасан	
		ШТМ хөрсөнд алдагдсан үед хусаж авах, саармагжуулах, цэвэрлэх арга хэмжээ авах, шаардлагатай багаж материалыг бэлтгэх /элс, хүрз, ус, саармагжуулагч бодис гэх мэт/	Засварын газар, ШТС	Асгаралтын иж бүрдэл	800,000	1	Хэрэгцээт үед	800,000	
4	Газрын хэвлий	Уурхайн ашиглалт, дэд бүтцийн хэмжээнд эвдэгдэж байгаа газрын хэмжээг тодорхойлох, бүртгэл хөтлөх	Төслийн үйл ажиллагааны хэмжээнд	га	-	-	Жилийн турш	Дотоод зардлаар	

5	Ургамалан нөмрөг	Уурхайн тэлэлтийн явцад олон тооны машин техник ажиллах тул тэдгээрийн хөдөлгөөний чиглэл явах маршрутыг нарийн төлөвлөж, уурхайн тэлэлт хүртэл уурхайн олборлолт эхлэхээс өмнө шинээр зам тавих	Төслийн талбайн хэмжээнд	км	-	-	Жилд нэг	Дотоод зардлаар	“Байгаль орчныг хамгаалах тухай”, “Байгалийн ургамалын тухай” хууль, БОНБНУ, дотоод журмууд
		Өмнөх жилүүдэд тарьсан модны усалгааг тогтмол гүйцэтгэх	Төслийн талбайн хэмжээнд	Нэгж суулгац	10,000	250	Жилийн турш	5,000,000	
		<b>Нийт</b>						<b>7,900,000</b>	

## 6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Уурхайн 2023 оны уулын ажлын төлөвлөгөөнд уурхайн үйл ажиллагаанд 60 га талбай өртөхөөр төлөвлөгөөнд тусгагдсан ба энэхүү төлөвлөгдсөн талбайн гүйцэтгэлээр шимт хөрсийг хуулна.

“Хар сэрвэгэн” лицензийн талбайн уурхайн олборлолтод өртөх хэсэг нь харьцангуй бага байгаа бөгөөд 2023 онд зөвхөн уулын ажлын тэлэлт хийгдэх учраас нөхөн сэргээх талбай одоогоор байхгүй байна.

**Хүснэгт 6. 2023 оны нөхөн сэргээлтийн төлөвлөгөө**

Нөхөн сэргээлтийн төрөл	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Нөхөн сэргээлтийн бэлтгэл ажил	Шимт хөрс хуулах	га	Уулын ажлын гүйцэтгэлээр хийнэ.	5,000,000	Жилийн туршид	MNS 5916:2008
<b>Нийт</b>				<b>5,000,000</b>		

## 7. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн Гуравдугаар зүйлийн 3.1.11-д "биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах" гэж төслийн үйл ажиллагаанд өртөгдөн унаган төрх, хэв шинж, амьдрах орчноо алдсан биологийн олон янз байдлыг өөр газарт нөхөн хамгаалах арга хэмжээг хэлнэ гэж тодорхойлсон байдаг. MV-017162 болон MV-019149 тоот тусгай зөвшөөрлийн нийт талбайд биологийн олон янз байдлын судалгаа шинжилгээг 2022 онд мэргэжлийн байгууллага болох “Их монголын байгаль” ХХК-аар гүйцэтгүүлсэн. Энэ онд бид Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжүүлэх боломжтой ажлыг төлөвлөгөөнд тусган ажиллах байна.

**Хүснэгт 7. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө**

	Хэрэгжүүлэх аргахэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, сая.төг	Хамтран хэрэгжүүлэгч	Биелэлтийн шалгуур	Нийт зардал, төгрөг	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Бэлчээрийн менежмент зохион байгуулж байгаа талбайг техноген үйл ажиллагаанаас хамгаалахын тулд / машины зам, эвдрэл, бохирдол/ “Энэ талбайд бэлчээрийн менежментийн арга хэмжээ явуулж байна” гэсэн утгатай пайз тавьж тэмдэгжүүлэх	Ноёны нуруу явах зам дагуу	6	150,000		Бэлчээрийн менежментийг хэрэгжүүлэх талбайн эргэлтийн цэгүүдийг байгуулна. Сэлгэж амраасны дараа бэлчээрийн ургамлын гарц нэмэгдсэн байна	1.000.000	Байгаль орчныг хамгаалах тухай”, “Байгалийн ургамалын тухай”
2	Зонхилох бэлчээрийн нэгж талбар бүрд ургамалжлын судалгааны мониторинг цэг байгуулна. Ойролцоогоор 6-аас багагүй цэгт	Ноёны нуруу	6	2,000,000		Бэлчээрийн төлөв байдал тодорхойлох, ургамлын зүйлийн өөрчлөлт илрүүлэх, амьтны тархалт ажиглах цэг болно	17,000.000	хууль, БОНБНУ, дотоод журмууд

3	Мониторинг цэгийг тэмдэгжүүлэх, пайз хадах ажил	Ноёны нуруу	6	5,000,0		Мониторинг цэгийн координат, бэлчээрийн төрлийг бичсэн пайз хадна.	6,000.000
4	Бэлчээрийн мониторинг цэг бүрд 5,6,7,8,9,-р саруудад дараах үзүүлэлтүүдээр -Зүйлийн бүрдлийн өөрчлөлт -Бэлчээрийн ургамалжлын бүрхцийн өөрчлөлт -Бэлчээрийн ургацын өөрчлөлт	Ноён нуруу	1	5,000,000		Жил бүрийн бэлчээрийн төлөв байдлыг энэхүү цэгүүдэд хянаж болно	6,000.000
5	Хөдөлгөөн мэдрэгч бүхий камераар амьтаны мониторинг судалгааг хийх	Ноёны нуруу	Тогтсон цэгүүд	2,000,000		Сар тутамд мэдээллийг хуулж авах замаар мэдээллийн сан үүсэх	7,000,000
6	Ган зудтай үед шаардлагатай газруудад биотехникийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх	Ноён сумын хэмжээнд	Нэгж шалгалт	5,000,000	1	Жилд нэг	5,000,000
							<b>44.000.000</b>

## 8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

### 8.1. Болзошгүй нөлөөллийн товч тодорхойлолт

Уурхайн үйл ажиллагаанаас болж нийгэм эдийн засагт дараах хэд хэдэн төрлийн нөлөөлөл үүсч болзошгүй юм.

- *Олон нийтийн эрүүл мэндийн болон аюулгүй байдал:*
- *Малын бэлчээрийн талбай багасах*
- *Малчид болон нутгийн оршин суугчид, зарим хэрэглэгчдийн эрх ашиг хөндөгдөх*

**Төсөл хэрэгжүүлэгчийн нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох чиглэлээр хэрэгжүүлж буй арга хэмжээ:** “Энхтунх Орчлон” ХХК нь “Хар сэрвэгэн” нүүрсний төслийн хүрээнд уурхайн нөлөөлийн бүсийг тогтоож, нөлөөлөлд өртөх айл өрхүүдийн судалгааг гаргасны үндсэн дээр айлуудыг нүүлгэн шилжүүлж, нөхөн олговрыг бүрэн олгосон. Иймээс 2023 онд энэ чиглэлийн ажил төлөвлөгөдөөгүй болно.



## 9. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Хар Сэрвэгэн” уурхайн тусгай зөвшөөрөл бүхий талбай 2012-2013 онуудад археологи палеонтологийн хайгуул судалгааны ажлыг эрдэм шинжилгээний байгууллагуудаар гэрээгээр гүйцэтгүүлсэн бөгөөд уурхайн талбайд нийт 16 дурсгал тодорхойлогдсоныг **авран хамгаалах ажлыг** Шинжлэх Ухааны Академийн Түүх Археологийн хүрээлэнгийн эрдэмтэд судлаачидтай хамтран гүйцэтгэсэн. Төслийн талбайд үйл ажиллагаа явуулж ирэхэд ямар нэгэн нэмэлт түүхийн дурсгал илрээгүй байна.

**Хүснэгт 8. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө**

Нөлөөлөлд өртөх түүх соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Тоо хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
